



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/73

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, “2023 оны төсөв батлах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийг үндэслэн Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх устгал тэмцлийн ажлыг 300,000,000 (гурван зуун сая) төгрөгөөр “Гранд форест” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан “Гранд форест” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 300,000,000 (гурван зуун сая) төгрөгийг гэрээний дагуу, Засаг даргын Тамгын газрын байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

